



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитын тайлан

Говьсүмбэр аймгийн 2016 оны нэгдсэн
төсвийн гүйцэтгэл



**Орон нутгийн төсвийн орлого, зарлагын
төлөвлөгөөг оны эцэст орлого,
зарлагын гүйцэтгэлд тохируулан
тодотгон баталсан байна.**

2017 он

2017 оны 04 дүгээр сар

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u> Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар Дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа Ахлах аудитор Д.Оюунбат Аудитор Г.Наранбаяр 2017 оны 04 дүгээр сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7054-3151, 7054-3179 дугаарын утсаар харилцана уу. ХАЯГ: Аймгийн Засаг даргын тамгын газрын байр, 2 давхар, 217 тоот	Товчилсон үгийн тайлбар4 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....5 Бүлэг 1. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын төлөвлөгөөг оны эцэст орлого, зарлагын гүйцэтгэлд тохируулан тодотгон баталсан байна. 1.1. 2016 оны төсвийн төслийг боловсруулахдаа Сангийн яамнаас өгсөн чиглэлийн заримыг нь бүрэн хангаж ажиллаагүй байна. 1.2. Орон нутгийн холбогдох байгууллагуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй байгаагаас төсвийн орлогыг бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөж, батлуулаагүй байна. 1.3. Орон нутгийн төсвийн зарлагыг тооцоо судалгаагүй төлөвлөж, үндэслэлгүй нэмэгдүүлсэн байна. 1.4. Орон нутгийн төсвийн тэнцлийн алдагдлыг нөхөх эх үүсвэрийг үнэн зөв тооцсон байна. Бүлэг 2. Орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 580.7 сая төгрөг буюу 11.7 хувиар давж биелсэн байна. 2. 2.1. Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 11.8 хувь буюу 507.8 сая төгрөгөөр давж биелсэн байна. 2.2. Орон нутгийн татварын бус орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 72.9 сая төгрөг буюу 11.3 хувиар давж биелсэн боловч орлогын нэр төрлөөрөө тасарсан байна. 2.3. Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 2016 онд бүрэн олгосон байна. 2.4. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлэг бүрэн санхүүжигдсэн байна. 2.5. Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтийг бүрэн олгосон байна. 2.6. Тэнцлийн ашгийг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна. Бүлэг 3. Төсвийн хөрөнгийг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан боловч зарим зардлыг үр ашиггүй зарцуулсан байна. 3.1. ТЕЗ-ийн батлагдсан төсөв нийт дүнгээрээ хэмнэгдсэн хэдий ч, төсвийн зарцуулалттай холбоотой зөрчил дутагдал байсаар байна. 3.2. 2016 оноос төсөл сангийн орлого, зарлагыг төлөвлөж, төсвийн гүйцэтгэлийн тайланд тайлагнадаг болсонтой холбоотой ТЕЗ-ийн тайлангийн авлага нэмэгдсэн байна.
--	--

	3.3. Төсвийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих дотоод хяналт үр дүнгээ өгч байна. 3.4. “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийг хангуулж, дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна. Дүгнэлт..... Зөвлөмж.....
--	--

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
МУЗГ	Монгол улсын Засгийн газар
ГСА	Говьсүмбэр аймаг
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
УБСГ	Улсын бүртгэл, статистикийн газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот, байгуулалтын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨҮААГ	Орон нутгийн өмчит үйлдвэр, аж ахуйн газар
ХК	Хувьцаат компани
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ХБГ	Хүлээгдэж байгаа гүйцэтгэл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийх бүрэн эрх, үндэслэл: Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил, үйлчилгээний төлөвлөгөө, Говьсүмбэр аймаг дахь Төрийн Аудитын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт:

Говьсүмбэр аймгийн 2016 оны орон нутгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийж, дүнг ҮАГ, аймгийн ИТХ болон Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх, аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгуулах, давтан гаргуулахгүй байхад аудитын зорилго чиглэгдлээ.

Аудитын хамарсан хүрээ:

Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авдаг, орон нутгийн орлого бүрдүүлдэг байгууллага, аж ахуйн нэгж, ТЭЗ-ийн 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан, тэнцэл судалгаа мэдээлэл, бусад баримт материалуудад тулгуурлан гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй:

Аудитын явцад асуудлыг шинжлэхдээ аудитыг АДБОУС 1000-1800, Төрийн хяналт шалгалтын стандарт, Санхүүгийн аудитын гарын авлага, холбогдох журмуудыг ашиглахаас гадна холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, шаардлагатай мэдээ, судалгааг гаргуулан авч, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан, нотлох зүйл цуглуулж аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараахь хууль, тогтоомжийг шалгуур үзүүлэлт болгов.

- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль,
- Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
- Нийгмийн даатгалын багц хуулиуд
- Төрийн аудитын тухай хууль
- Татварын багц хуулиуд
- УИХ-ын 2015 оны 108 дугаар тогтоол
- УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоол
- Бусад холбогдох хууль тогтоомж, журам, заавар

Үндсэн мэдээлэл:

2016 онд орон нутгийн төсвийн орлогод 16,828.0 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна. Эх үүсвэрийн хувьд:

- орон нутгийн орлогоос 4,934.9 сая,
- санхүүгийн дэмжлэг 16.5 сая,
- ОНХС-ийн нэгдсэн сангаас санхүүжилт 2,227.4 сая,
- тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 7,758.4 сая,
- төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого 1,232.2 сая,
- 2015 оны тэнцлийн ашиг 658.6 сая төгрөгийг тус тус бүрдүүлэхээр төсвийг алдагдалгүй төлөвлөсөн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэмжээнд 2016 онд нийт 16,828.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж батлуулснаас 14,704.0 сая төгрөг зарцуулж, төсөв 2,124.0 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна. Нийт хэмнэгдсэн зардлын 40.3 хувь нь бодит бус хэмнэлт байна.

Энэ нь ТЕЗ-ийн 2016 оны төсвийн зарлагад сумдын СХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс олгох зээлийн дүнг оруулж баталсан боловч сангийн эх үүсвэр бүрдээгүйгээс зээл олголт төлөвлөсөн хэмжээгээр олгогдоогүй, мөн төсөвт байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөгөө тасарсантай холбоотой төсөв хэмнэгдсэн мэт харагдаж байна.

ТЕЗ-ийн 2016 оны нийт төсвийн гүйцэтгэлийн 47.3 хувь буюу 6,961.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт байгууллага, 52.7 хувь буюу 7,743.0 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын төсөв эзэлж байна.

Орон нутгийн төсвийн орлого, зарлагын төлөвлөлт
үндэслэлтэй хийгдсэн эсэх

Бүлэг 1

Орон нутгийн төсвийн орлого, зарлагын төлөвлөгөөг оны эцэст орлого, зарлагын гүйцэтгэлд тохируулан тодотгон баталсан байна.

1.1. 2016 оны төсвийн төслийг боловсруулахдаа Сангийн яамнаас өгсөн чиглэлийн заримыг нь бүрэн хангаж ажиллаагүй байна.

Монгол Улсын Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагууд нь макро түвшиний асуудлууд учраас орон нутгийн түвшинд баримтлах боломжгүй юм.

Сангийн яамнаас ТЕЗ-ийн 2016 оны орон нутгийн төсвийн төлөвлөгөөг боловсруулах, гүйцэтгэлийг зохион байгуулах ажлын хүрээнд төсвийн төслийг боловсруулахтай холбоотой Сангийн сайдын 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 4-1/4198 дугаар бүхий албан бичгийг ирүүлсэн байна.

Тус албан бичигт ТЕЗ нарын 2016 оны төсвийн төсөл, 2017-2018 оны төсвийн төсөөлөл бэлтгэх удирдамжид төсвийн жилийн онцлог, анхаарах зүйлс, төсвийг хумих бодлого баримтлах шаардлага бий болсонтой холбоотой зарим зардлыг хязгаарлах шаардлагатай байгааг анхааруулсан байна. Үүнд:

1. Орон тоо, цалин хөлс болон тэтгэвэр, тэтгэмжийг 2015 оны түвшинд хадгалах,

2. Ирэх онд шинээр ашиглалтанд орох барилга байгууламжийн ашиглалтаас бусад тохиолдолд тавилга эд хогшил авахгүй байх,
3. Гадаад томилолтыг 100 хувь бууруулах, зочин хүлээн авах, мэдээлэл сурталчилгааны зардлыг 50 хувиар бууруулах,
4. Хөрөнгө оруулалтын зардлыг бүх шатанд бууруулах
5. Орон нутгийн тэнцлийн ашгийг 100 хувь улсын төсөвт төвлөрүүлэх гэх мэт

Орон нутгийн түвшинд эдгээр чиглэлийг хэрхэн хангаж ажилласан талаар шалгуур болгож авч үзлээ.

Говьсүмбэр аймаг нь 2016 оны орон нутгийн төсвийн төлөвлөгөөг боловсруулж, гүйцэтгэлийг зохион байгуулах, төсвийн сар, улирлын хуваарийг боловсруулахдаа Сангийн яамнаас ирүүлсэн чиглэлийн заримыг нь хангаж ажиллаагүй байна. Тухайлбал:


- Хөрөнгө оруулалтын зардлыг 2.8 хувь буюу 87.9 сая, орон тоог нэмэгдүүлж, цалин, шимтгэлийн зардлыг 46.9 сая, зочин төлөөлөгч хүлээн авах зардлыг 3.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж баталсан
- Төсөвт байгууллагуудын төсвийн урамшууллын 157.3 сая төгрөгийг 2016 оны төсвийн хуваарьт оруулж хуваарилсан байна.

1.2. Орон нутгийн холбогдох байгууллагуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй байгаагаас төсвийн орлогыг бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөж, батлуулаагүй байна.

Орон нутгийн төсвийн орлого, зарлагыг өмнөх онуудын суурь орлого, суурь зарлага болон төсөвт байгууллагуудын ирүүлсэн саналд үндэслэн төлөвлөдөг боловч төсвийн орлого, зардлыг хянаж, төлөвлөхөд ашиглах суурь судалгаа, тоо мэдээ багатайгаас төсвийн төлөвлөлт үндэслэлгүй хийгдэж байна.

2016 онд улсын төсөвт 2,554.0 сая, орон нутгийн төсөвт 4,934.9 сая төгрөг тус тус төвлөрүүлэхээр батлуулсан байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг өмнөх онтой харьцуулсан судалгааг графикаар харуулбал:



Графикаас харахад: 2016 оны улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 66.4 сая төгрөгөөр бууруулан төлөвлөсөн байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөлтийг өмнөх жилүүдийн гүйцэтгэл болон тухайн жилийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлд үндэслэн төлөвлөж байгаа боловч он дамжин төлөгдөх татварын авлагын тооцоо, тайлант онд шинээр үүсгэн байгуулагдаж, улсын бүртгэлд бүртгүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагуудын орлогын

судалгааг үндэслэн улсын төсвийн орлогын боломжит эх үүсвэрүүдийг үнэн, зөв тооцож, төлөвлөөгүй байна.

Тухайлбал: 2016 онд улсын төсвийн орлогын төлөвлөгөөг 66.4 сая төгрөгөөр бууруулж төлөвлөсөн байхад гүйцэтгэлээр орлого 151.3 сая төгрөг буюу 5.9 хувиар давж биелсэн байна.

2016 оны татварын зарим нэр төрлийн орлогыг үндэслэлгүй төлөвлөснөөс төсөвт 4 удаа тодотгол хийгдэж орон нутгийн орлогын төлөвлөгөөг нийт 1,237.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

2016 оны анх батлагдсан орон нутгийн орлогын төлөвлөгөөг сүүлийн тодотголоор батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

					/сая төгрөгөөр/
№	Орлогын нэр төрөл	АИТХ-аас анх баталсан 2016 оны орлого	Сүүлийн төсвийн тодотгол	Зөрүү	
1	Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар	2 827.6	2 862.6	- 35.0	
2	ХХОАТ-ын буцаан олголт	(230.0)	(222.3)	- 7.7	
3	ҮХЭХ-ийн албан татвар	240.0	240.0	-	
4	АТБӨЯХ-ийн албан татвар	90.4	85.5	4.9	
5	Улсын тэмдэгтийн хураамж	50.4	50.0	0.4	
6	Газрын төлбөр	89.3	110.3	- 21.0	
7	Ус ашигласны төлбөр	793.5	901.7	- 108.3	
8	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	-	-	-	
9	Дуудлага худалдааны орлого	-	19.9	19.9	
10	Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	44.0	44.0	-	
11	Суутгагчийн хувь хүнд олгосон ОАТ	90.0	67.1	22.9	
12	Үйл ажиллагааны орлого	50.5	45.6	4.9	
13	Бууны албан татвар	4.8	4.0	0.8	
14	Хог хаягдлын хураамж	87.5	80.7	6.7	
Аймгийн татварын орлогын нийт дүн		4 137.9	4 289.2	- 151.2	
1	Түрээсийн орлого	71.8	56.5	15.2	
2	Төсвийн байгууллагын өөрийн орлого	48.8	52.4	- 3.6	
3	Хүү, торгуулийн орлог	230.4	589.2	- 358.8	
Аймгийн татварын бус орлогын нийт дүн		350.9	698.1	- 347.2	
1	Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	4.3	16.5	- 12.1	
2	Тусгай зориулалтын шилжүүлэг	7 500.8	7 758.3	- 257.6	
3	Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг	2 453.4	2 227.4	225.9	
Улсын төсвөөс авах шилжүүлгийн нийт дүн		9 958.5	10 002.3	- 43.7	
1	ТЗШ-ийн байгууллагын өөрийн орлого	46.3	46.7	- 0.4	
ТЗШ-ийн өөрийн орлогын нийт дүн		46.3	46.7	- 0.4	
1	2015 оны тэнцлийн ашгаас /ОНХС/	226.2	556.4	- 330.2	
2	2015 оны тэнцлийн ашгаас /Байгууллага/	-	102.2	- 102.2	
2015 оны тэнцлийн ашгаас		226.2	658.6	- 432.4	
1	2015 оны дансны үлдэгдэл /ОНХС/	-	157.3	- 157.3	
2015 оны дансны үлдэгдэл /ОНХС/		-	157.3	- 157.3	
1	Сумдын Сум хөгжүүлэх сан	841.0	928.8	- 87.8	
2	Сумдын Байгаль хамгаалах сан	26.8	35.0	- 8.1	
3	Сумдын Мал хамгаалах сан	2.5	11.8	- 9.3	
Сумдын сангуудаас орох орлогын нийт дүн		870.4	975.7	- 105.3	
НИЙТ ДҮН		15 590.2	16 828.0	- 1 237.8	

Хүснэгтээс харахад: орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 7.94 хувь буюу нийт 1,237.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Үүнээс улсын төсвөөс авах шилжүүлгийн дүн 0.27 хувь, орон нутгийн нийт орлого 3.19 хувь, төсөвт байгууллагын өөрийн орлого 4.48 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Тухайлбал: 2016 оны төсөвт 4 удаа тодотгол хийсэн бөгөөд Сүмбэр сумын орлогын төлөвлөгөөг суутгагчийн хувь хүнд олгосон орлого тасарсан шалтгаанаар 35.0 сая төгрөгөөр бууруулж, цалин хөлс түүнтэй адилтгах орлогыг нэмэгдүүлсэн, Шивээговь сумын орлогын төлөвлөгөөнд аж ахуй эрхэлсний орлогыг 4.9 сая, бууны татварын орлогыг 0.8 сая, улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг 0.4 сая, хог

хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг 4.0 сая төгрөгөөр тус тус бууруулж, суутгагчийн хувь хүнд олгосон орлогын төлөвлөгөөг 10.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр орлогын нэр төрөлд өөрчлөлт оруулсан байна.

Орон нутгийн орлогыг төлөвлөхдөө орлогын нэр, төрлийг бодит тоон мэдээлэл, судалгаанд үндэслэн үнэн зөв төлөвлөөгүйгээс тайлант оны эцэст орлогын төлөвлөгөөг орлогын гүйцэтгэлд тохируулан тодотгон баталсан байна.

1.3. Орон нутгийн төсвийн зарлагыг тооцоо судалгаагүй төлөвлөж, үндэслэлгүй нэмэгдүүлсэн байна.


Говьсүмбэр аймгийн ТЭЗ-ийн 2015 оны ХБГ 17,042.1 сая төгрөг байсан ба 2016 оны төсвийн төсөлд 16,460.5 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, санал хүргүүлснээс УИХ-аас 14,015.9 сая төгрөгөөр батлагдаж ирсэн байна. Үүнд: Орон нутгийн суурь зарлага 4,039.0 сая, ТЗШ-ийн байгууллагын зарлага 7,523.5 сая, ОНХС-ийн зарцуулалт 2,453.4 сая төгрөгөөр тус тус батлагдсан байна.

Тайлант онд УИХ-аас батлагдсан 14,015.9 сая төгрөгийн зарлагын төсвийг аймгийн ИТХ 11.2 хувь буюу 1,574.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 15,590.2 сая төгрөгөөр баталсан байна.

УИХ-аас батлагдаж ирсэн төсвийн зарлагыг нэмэгдүүлэхдээ: төсвийн суурь зарлагыг 5.6 хувь буюу 224.2 сая, ТЗШ-ийн байгууллагуудын төсвийг 0.3 хувь буюу 23.6 сая, ОНХС-ийн төсвийг 18.6 хувь буюу 456.2 сая, сумдын сангуудын төсвийг 100 хувь буюу 870.3 сая төгрөгөөр тус тус нэмсэн байна.

Тайлант хугацаанд АИТХ анх баталсан төсвөө 4 удаа тодотгож, жилийн эцэст 7.9 хувь буюу 1,237.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 16,828.0 сая төгрөг зарцуулахаар баталсан байна.

Нэмэгдсэн төсвийг салбар болон зардлын төрлөөр нь ангилж графикаар харуулбал дараах байдалтай байна.



Графикаас харахад: Орон нутгийн суурь зарлага 3.5 хувь буюу 148.7 сая, ТЗШ-ийн байгууллагын зарлага 3.4 хувь буюу 258.0 сая, ОНХС-ийн зарцуулалтыг 24.9 хувь буюу 725.7 сая, СХС болон БХС, МХС-ийн зарцуулалтыг 12.1 хувь буюу 105.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

2016 оны тодотгосон төсвийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулсан судалгааг дараах хүснэгтээр харуулбал:

/сая төгрөг/

№	Зардал бүлгийн төрлөөр	Өмнөх оны гүйцэтгэл	2016 оны сүүлийн тодотгосон төсөв	Зөрүү	
				Дүн	Хувь
	Нийт зарлага дүн	14,925.9	16,828.0	-1902.1	-12.7
1	Цалин, нэмэгдэл урамшуулал	6,224.2	6,200.2	24.0	0.4
2	НДШ-ийн зардал	698.8	746.6	-47.8	-6.8
3	Тогтмол зардал	1,074.2	1,472.5	-398.2	-37.1
4	Хангамж бараа материалын зардал	235.4	266.0	-30.6	-13.0
5	Нормативт зардал	301.7	414.9	-113.2	-37.5
6	Эд хогшил, урсгал засварын зардал	107.6	100.4	7.3	6.7
7	Томилолт, зочны зардал	75.6	45.4	30.2	39.9
8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	268.4	213.3	55.1	20.5
9	Бараа үйлчилгээний бусад зардал	1,243.2	1,020.9	222.3	17.9
10	Татаас	198.4	222.2	-23.8	-12.0
11	Бусад урсгал шилжүүлэг	1,345.3	1,955.9	-610.6	-45.4
12	Хөрөнгийн зардал	3,152.9	3,240.8	-87.9	-2.8
13	Эргэн олгох зээл		928.8	-928.8	-100.0

Хүснэгтээс харахад: Төсвийн зарлагыг нийт дүнгээр нь өмнөх оноос 12.7 хувь буюу 1,902.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан бөгөөд үүнээс тогтмол зардлыг 37.1 хувь буюу 398.2 сая, нормативт зардлыг 37.5 хувь буюу 113.2 сая, хангамжийн бараа материалын зардлыг 13.0 хувь буюу 30.6 сая, татаас шилжүүлгийн зардлыг 12.0 хувь буюу 23.8 сая, бусад урсгал шилжүүлгийг 45.4 хувь буюу 610.6 сая, хөрөнгийн зардлыг 2.8 хувь буюу 87.9 сая, эргэн олгох зээлийн зардал 100 хувь буюу 928.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

ТЕЗ-ийн 2016 оны төсвийн төслийг боловсруулахтай холбоотой Сангийн сайдын 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 4-1/4198 дугаар бүхий албан бичигт ТЕЗ нарын 2016 оны төсвийн төсөл, 2017-2018 оны төсвийн төсөөлөл бэлтгэх удирдамжид төсвийг хумих бодлого баримтлах шаардлага бий болсонтой холбоотой зарим зардлыг хязгаарлах шаардлагатай байгааг анхааруулсан байна. Үүнд:

1. Орон тоо, цалин хөлс болон тэтгэвэр, тэтгэмжийг 2015 оны түвшинд хадгалах,
2. Ирэх онд шинээр ашиглалтанд орох барилга байгууламжийн ашиглалтаас бусад тохиолдолд тавилга эд хогшил авахгүй байх,
3. Гадаад томилолтыг 100 хувь бууруулах, зочин хүлээн авах, мэдээлэл сурталчилгааны зардлыг 50 хувиар бууруулах,
4. Хөрөнгө оруулалтын зардлыг бүх шатанд бууруулах
5. Орон нутгийн тэнцлийн ашгийг 100 хувь улсын төсөвт төвлөрүүлэх

ТЕЗ-ийн 2016 оны төсвийн төслийг боловсруулахдаа төсөвт байгууллага болон сумдын төсвийн саналыг авдаг боловч ирсэн саналд дүгнэлт, судалгаа шинжилгээ хийхгүй зөвхөн тоо, мэдээг нэгтгэх төдийгөөр хязгаарлагдаж байгаагаас орон нутгийн төсөв үндэслэлгүй төлөвлөгдсөөр байна. Үүнд:

- Өмнөх оны тогтмол зардал нийт 101.0 сая төгрөгөөр хэмнэгдсэн ба Сангийн сайдаас ТЕЗ-ийн 2016 оны төсөвт баримтлах санамж бичигт тогтмол зардлыг 17.0-34.0 хувиар өсгөх чиглэл өгсөн байхад 37.1 хувиар нэмэгдүүлсэн нь үндэслэлгүй байна. Тухайлбал: Гэрэл цахилгааны төсөв жил бүр хэмнэгддэг бөгөөд 2015 онд 31.8 хувь буюу 43.2 сая төгрөгөөр хэмнэгдсэн байхад гэрэл

цахилгаан зардлыг 2016 оны төсвийн төсөлд 69.8 хувиар нэмэгдүүлж баталсан байна. Энэ нь төлөвлөлтийг өмнөх оны гүйцэтгэл болон тооцоо, судалгаанд үндэслээгүйтэй холбоотой байна.

- Бусад урсгал шилжүүлгийн зардлыг 45.4 хувиар нэмэгдүүлж төлөвлөсөнд нөлөөлсөн хүчин зүйл нь нийгмийн халамжийн сангийн зардал байна. Тухайлбал: 2015 онд халамжийн сангийн зардал 23.7 хувь буюу 322.0 сая төгрөгөөр хэмнэгдсэн байхад 2016 оны төсвийн төслийг өмнөх оны гүйцэтгэлээс 30.8 хувь буюу 319.7 сая төгрөгөөр нэмж баталсан байна. Энэ нь мөн л анхан шатны байгууллагаас ирсэн төсвийн төслийн саналд дүн шинжилгээ хийгээгүйтэй холбоотой байна.
- Өмнөх оны төсвийн зарлагын төлөвлөгөөг нэмэгдүүлсэн нэг хүчин зүйл бол сумдын сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс олгох зээлийг 2016 оноос төсвийн зарлагын төлөвлөлтөд оруулж төлөвлөдөг болсонтой холбоотой байна. 2016 оны төсвийн төсөлд тус сангийн зардлын тусгавал зохих дүнг зарим сумдад илүү, дутуу төлөвлөсөн байна.
- Хөрөнгө оруулалтын зардлыг 2.8 хувь буюу 87.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан нь Сангийн сайдаас ирүүлсэн чиглэлд хөрөнгө оруулалтын зардлыг бүх шатанд бууруулах гэсэнтэй нийцээгүй байна.
- Төсөвт байгууллагуудын төсвийн урамшууллын 157.3 сая төгрөгийг 2016 оны төсвийн хуваарьт оруулж хуваарилсан байна.
- Аймгийн ИТХ өөрийн байгууллагын урсгал төсвийг батлахдаа 2015 онд УИХ-аас батлагдсан төсвийг 87.0 хувиар нэмж зарцуулсанд өмнөх оны аудитаар зөвлөмж өгсөн боловч хэрэгжүүлээгүй, 2016 оны төсвийг 88.2 хувь буюу 100.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан бөгөөд нэмэгдсэн зарим зардлын зүйл анги нь Сангийн яам, УИХ-аар хянагдаагүй зардал байна.

Энэ нь Засгийн газрын 2016 оны 47 тогтоолын 2-т заасан “төсвийн зардлыг хэмнэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх” гэсэнтэй нийцэхгүй байна. Тухайлбал: орон тоог 2-оор нэмэгдүүлж цалин, шимтгэлийн зардлыг 46.9 сая, тээвэр шатахууны зардлыг 10.0 сая, зочин төлөөлөгч хүлээн авах зардал 3.9 сая, урсгал засварын зардал 1.0 сая, хурлын нөөц сан 20.0 сая, УИХ-д суудалтай намуудын дэмжлэг 17.0 сая, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 2.1 сая төгрөгөөр тус тус нэмсэн байна.

Иймд Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3 “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь аймаг, нийслэлийн төсөвт, аймаг нийслэлийн Засаг дарга нь сум дүүргийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг, тусгай зориулалтын шилжүүлгийг дараах зөрчил илэрсэн тохиолдолд түүнийг арилгах хүртэлх хугацаанд түр зогсоох эрхтэй”, 56.3.2-т “иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн жилийн төсвөө үндэслэлгүйгээр нэмэгдүүлж баталсан”, мөн УИХ-ын 2015 оны 108 дугаар “Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын 14-т “баталсан төсвөө хэтрүүлсэн, орон тоог үндэслэлгүй нэмэгдүүлсэн бүх шатны төсвийн захирагчид Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох” гэсний дагуу арга хэмжээ тооцуулах саналтай байна.

2016 оны төсвийг боловсруулж, батлахдаа баримтлах Сангийн сайдын өгсөн зөвлөмжийг бүрэн хангаж ажиллаагүй, төсвийг зарцуулахдаа УИХ-ын “төсвийн зардлыг хэмнэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх” гэсэн 47 дугаар тогтоолыг мөрдлөг болгоогүй байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулдаг байх” гэснийг тус тус зөрчсөн байна.

1.4. Орон нутгийн төсвийн тэнцлийн алдагдлыг нөхөх эх үүсвэрийг үнэн зөв тооцсон байна.

Аймгийн ИТХ-аар 2016 оны орон нутгийн төсөвт тэнцлийн алдагдлыг нөхөх эх үүсвэрийг 2015 оны ХБГ-ийг үндэслэн тооцож 226.2 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр анх төлөвлөсөн боловч тайлант онд төсөвт 2 удаа тодотгол хийж, аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 03, Сүмбэр сумын ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 09, Баянтал сумын ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 12, Шивээговь сумын ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 07 дугаартай тогтоолуудаар нийт 658.6 сая төгрөг болгон, 2015 оны жилийн эцсийн төсвийн хэмнэлт болон ОНХС-гийн гэрээний хэмнэлтийн бодит үлдэгдлийн нийт 432.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх

Бүлэг 2

Орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 580.7 сая төгрөг буюу 11.7 хувиар давж биелсэн байна.

2.1. Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 11.8 хувь буюу 507.8 сая төгрөгөөр давж биелсэн байна.


2016 онд орон нутгийн төсөвт татварын болон татварын бус орлого 4,934.9 сая төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 5,515.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 580.7 сая төгрөг буюу 11.7 хувиар давж биелсэн байна.

2016 онд Сангийн яамнаас орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 3,864.8 сая төгрөгөөр хянагдаж ирсэн бөгөөд 2015 оны 12 дугаар сард аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор 273.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 4,137.9 сая төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд төсөвт 4 удаа тодотгол хийж, орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг 151.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 4,289.2 сая төгрөгөөр баталсан байна.

Орон нутгийн татварын орлогын сүүлийн 2 жилийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгааг хүснэгтээр харуулбал:

Он	Татварын орлого		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлтийн хувь
2015	4,219.8	3,936.3	93.3
2016	4,289.2	4,797.0	111.8



Хүснэгтээс харахад орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 1.6 хувиар нэмэгдүүлэн төлөвлөсөн бөгөөд 2015 онд орлогын төлөвлөгөө 6.7 хувиар тасарч, орлогын төлөвлөгөөний биелэлт 93.3 хувьтай байсан бол тайлант онд төвлөрүүлсэн орлогын гүйцэтгэл 11.8 хувиар давж биелсэн бөгөөд өмнөх оны гүйцэтгэлээс 21.8 хувиар нэмэгдсэн байна.

2016 оны татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг нэр төрлөөр нь гаргасан судалгааг хүснэгтээр харуулбал:

		/сая төгрөгөөр/		
ТАТВАРЫН ОРЛОГЫН НЭР ТӨРӨЛ		Төлөв	Гүйц	Зөрүү
Татварын орлогын нийт дүн		4,289.2	4,797.0	507.8
1.1.Цалинхөлс түүнтэй адилтгах орлогын татвар		2,862.6	3,290.4	427.8
1.2.ХХОАТ-буцаан олголт		(222.3)	(222.3)	0.0
1.3.Орлогыг тодорхойлох боломжгүй иргэний татвар				
1.4.Суутгагчийн хувь хүнд олгосон орлогын албан татвар		67.1	91.7	24.6
1.5.Үйл ажиллагааны орлого		45.6	52.5	6.9
1.6.Хөрөнгө худалдсаны орлогын албан татвар		44.0	44.1	0.1
1.7.Үл хөдлөх хөрөнгийн албан татвар		240.0	262.3	22.3
1.8.Бууны татвар		4.0	5.9	1.8
1.9.Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татвар		85.5	86.6	1.1
1.10.Улсын тэмдэгтийн хураамж		50.0	58.8	8.8
1.11.Газрын төлбөр		110.2	120.4	10.2
1.12.Усны төлбөр		901.7	902.8	1.1
1.13.Агнуурын нөөц ашигласны төлбөр				-
1.14.Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр			1.5	100.0
1.15.Хог хаягдлын үйлчилгээний хураамж		80.7	82.2	1.5
1.16.Дуудлага худалдаа сонгон шалгаруулалт		19.9	19.9	-

Хүснэгтээс харахад: татварын орлогын төлөвлөгөөний биелэлт нийт дүнгээрээ 507.8 сая төгрөгөөр давж биелсэн ба орлогын нэр төрлөөрөө 0.12-100.0 хувиар буюу 0.1-427.8 сая төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

Орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн шалтгааныг тодруулбал:

- Орон нутгийн орлогын төлөвлөгөөг өмнөх оноос бууруулж төлөвлөсөн,
- Тайлант оны жилийн эцэст төсвийн тодотгол хийхдээ орлогын гүйцэтгэлээр төлөвлөгөөг баталсан
- Өмнөх оны дутуу төлөгдсөн татварын орлогууд он дамжин төлөгдсөн
- Орон нутгийн орлогыг бодит тоон мэдээлэл, судалгаанд үндэслэн үнэн зөв төлөвлөөгүйтэй холбоотой байна.

Тухайлбал: Оны эхэнд ус, рашаан ашигласны төлбөрийг өмнөх оноос 47.5 сая төгрөгөөр бууруулан 793.5 сая төгрөгөөр баталсан боловч 4 удаагийн төсвийн тодотголоор жилийн эцэст 901.7 сая төгрөг болгон баталсан байна.

Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

		/сая төгрөгөөр/					
ТАТВАРЫН ОРЛОГЫН НЭР ТӨРӨЛ		2015 он		2016 он		Зөрүү	
		Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц
1.1.Цалинхөлс түүнтэй адилтгах орлогын татвар		2 843.5	2 829.2	2 862.6	3 290.3	19.1	461.2
1.2.ХХОАТ-буцаан олголт		(220.2)	(220.2)	(222.3)	(222.3)	(2.1)	(2.1)
1.3.Орлогыг тодорхойлох боломжгүй иргэний татвар		15.6	16.9			(15.6)	(16.9)
1.4.Бусад татвар		97.8	102.5	67.1	91.7	(30.7)	(10.8)
1.5.Үйл ажиллагааны орлого		3.5	13.8	45.6	52.5	42.1	38.7
1.6.Хөрөнгө худалдсаны орлогын албан татвар		49.0	43.9	44.0	44.1	(5.0)	0.2
1.7.Үл хөдлөх хөрөнгийн албан татвар		240.0	222.2	240.0	262.3	-	40.1
1.8.Бууны татвар		0.6	0.8	4.0	5.9	3.5	5.0
1.9. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татвар		90.0	95.9	85.5	86.6	(4.5)	(9.3)
1.10. Улсын тэмдэгтийн хураамж		48.0	54.5	50.0	58.8	2.0	4.4

1.11.Газрын төлбөр	100.0	96.1	110.3	120.5	10.3	24.4
1.12. Усны төлбөр	841.0	528.4	901.7	902.8	60.7	374.5
1.13.Агнуурын нөөц ашигласны төлбөр	-	10.9			-	(10.9)
1.14.Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	11.0	43.6		1.5	(11.0)	(42.1)
1.15.Хог хаягдлын үйлчилгээний хураамж	85.0	81.4	80.7	82.2	(4.3)	0.8
1.16.Дуудлага худалдаа сонгон шалгаруулалт	15.0	16.1	19.9	19.9	4.9	3.9
1.17.Бусад татвар, хураамж	-	0.03			-	(0.03)
НИЙТ ДҮН	4 219.8	3 936.3	4 289.2	4 797.0	69.4	860.7

Хүснэгтээс харахад татварын зарим нэр төрлийн орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 4.3-5.0 сая төгрөгөөр бууруулж төлөвлөсөн боловч уг орлогууд нь гүйцэтгэлээр 0.26-1.83 хувь буюу 0.1-24.6 сая төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

Энэ нь зарим орлогын төлөвлөгөөг үндэслэлгүйгээр бууруулан баталснаас орлого давж биелсэн мэт харагдаж байна. Тухайлбал:

- Хөрөнгө борлуулсны орлогын төлөвлөгөөг 5.0 сая,
- Хог хаягдал, цэвэрлэгээ үйлчилгээний орлогын төлөвлөгөөг 4.0 сая,
- Аж ахуй эрхэлсний орлогоын төлөвлөгөөг 4.9 сая,
- Суутгагчийн хувь хүнд олгосон орлогын албан татварын орлогын төлөвлөгөөг 35.0 сая төгрөгөөр тус тус бууруулан баталсан байна.

Иймд бүрэн төвлөрөх боломжтой орлогын төлөвлөгөөг үндэслэлгүй бууруулж батлуулахгүй байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

2.2. Орон нутгийн татварын бус орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 72.9 сая төгрөг буюу 11.3 хувиар давж биелсэн боловч орлогын нэр төрлөөрөө тасарсан байна.

2016 онд Сангийн яамнаас орон нутгийн татварын бус орлогын төлөвлөгөө 140.2 сая төгрөгөөр хянагдаж ирсэн бөгөөд 2015 оны 12 дугаар сард аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор 161.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 302.1 сая төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд төсөвт 4 удаа тодотгол хийж, орон нутгийн татварын бус орлогын төлөвлөгөөг 343.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 645.7 сая төгрөгөөр баталсан байна.

Орон нутгийн татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

/сая төгрөгөөр/

Он	Татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлтийн хувь
2015	285.0	353.7	124.10
2016	645.7	718.6	111.29

Хүснэгтээс харахад: 2016 онд татварын бус орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 226.6 хувь буюу 360.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан бөгөөд гүйцэтгэлээр орлогын төлөвлөгөөг 111.3 хувиар давуулан биелүүлсэн байна.

2016 оны татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг татварын нэр төрлөөр нь гаргасан судалгааг хүснэгтээр харуулбал:

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
ТАТВАРЫН БУС ОРЛОГО		645.7	718.6	(72.9)
2.1.	Хүү, торгуулийн орлого	589.2	669.9	(80.7)
2.2.	Түрээсийн орлого	56.5	48.7	7.8

Хүснэгтээс харахад татварын бус орлого нийт дүнгээрээ 72.9 сая төгрөгөөр давж биелсэн боловч орлогын нэр төрлөөрөө түрээсийн орлого 7.8 сая төгрөг буюу 13.9 хувиар тасарсан байна.

Түрээсийн орлогын төлөвлөгөө 7.8 сая төгрөгөөр тасарсан нь тайлант онд орон нутгийн өмчийн албатай байгуулсан түрээсийн гэрээний дагуу Баянтал сумын “Чойр хайрхан” ХХК түрээсийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.

ТЕЗ-ийн хэмжээнд төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 79.7 хувь буюу 856.6 сая төгрөгөөр тасарсан байна.

Орон нутгийн төсөвт байгууллагын болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг диаграммаар харуулбал:



Орон нутгийн төсөвт байгууллагын болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой зэрэгцүүлсэн судалгааг байгууллага тус бүрээр харуулбал:

/сая төгрөгөөр/

№	Байгууллага	2015 он		2016 он	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Орон нутгийн төсөвт байгууллагын өөрийн орлого					
1	АЗДТГ	3.4	6.8	0.6	1.2
2	Цөм сүрэг үржлийн төв	45.4	32.4	31.1	29.6
3	Авто зам	12.0	15.8	18.6	19.0
4	Худалдан авах ажиллагаа	5.0	2.2		
5	Тохижилт-Сүмбэр	6.0	-	2.0	2.2
6	Халамжийн сан				1.8
7	Сүмбэр ЗДТГ	2.0	-		0.2
Дүн		73.8	57.3	52.4	54.0
Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын өөрийн орлого					
1	БТСГ	19.9	21.3	18.7	19.6
2	Музей	0.5	0.5	0.5	0.5

3	Номын сан	0.7	0.6	0.5	0.5
4	Боржигон чуулга	39.6	19.3	25.0	22.0
5	Шивээговь СТөв	1.0	1.9	1.0	1.0
6	Баянтал СТөв	1.0	1.0	1.0	1.1
7	Шивээговь ЭМТ	0.6	0.6		
8	Баянтал ЭМТ	0.5	-		
Дүн		63.6	45.1	46.7	44.7
Сумдын сангийн орлого					
1	Сумдын сум хөгжүүлэх сан			928.8	114.1
2	Сумдын Байгаль хамгаалах сан			35.0	3.4
3	Сумдын Мал хамгаалах сан			11.8	2.0
Дүн				975.7	119.5
НИЙТ ДҮН		137.5	102.4	1 074.8	218.2

Судалгаанаас харахад 2016 оны өөрийн орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 781.6 хувиар буюу 937.3 сая төгрөгөөр нэмж төлөвлөсөн байна. Энэ нь 2016 оноос сумдын СХС, БХС, МХС-гууд орлогын төлөвлөгөөг нэмж баталсантай холбоотой байна.

Өөрийн орлогын төлөвлөгөөг Цөм сүрэг үржлийн төв 1.6 сая, Боржигин чуулга 2.9 сая, Сумдын сангуудын орлого 856.2 сая төгрөг буюу 79.7 хувиар орлогын төлөвлөгөөг тасалсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.1-т “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд орон нутгийн төсөвт болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлээгүй, орлогын төлөвлөгөөг тасалсан төсвийн захирагч нарт зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

2.3. Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 2016 онд бүрэн олгосон байна.

2016 онд тус аймагт олгох санхүүгийн дэмжлэгийг анх 4.3 сая төгрөгөөр хянаж баталсан бөгөөд МУ-ын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар санхүүгийн дэмжлэгийг 12.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 16.5 сая төгрөгөөр баталж санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Санхүүгийн дэмжлэгийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

/сая төгрөгөөр/

Он	Санхүүгийн дэмжлэг		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлтийн хувь
2015	364.5	348.5	95.0
2016	16.5	16.5	100.0

Хүснэгтээс харахад 2016 онд улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 95.5 хувиар бууруулан төлөвлөсөн бөгөөд 2015 онд улсын төсвийн орлого тасарснаас санхүүгийн дэмжлэгийг 5.0 хувиар дутуу олгож байсан бол 2016 онд бүрэн олгосон байна.

2.4. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлэг бүрэн санхүүжигдсэн байна.

2016 онд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлэгийг УИХ-аас 2,453.4 сая төгрөгөөр хянаж, баталсан боловч МУ-ын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар 225.9 сая төгрөгөөр бууруулан 2,227.4 сая төгрөгөөр баталсан бөгөөд санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

/сая төгрөгөөр/

Он	ОНХС-гийн санхүүжилт		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлтийн хувь
2015	3 308.8	2 721.2	82.2
2016	2 227.4	2 227.4	100.0

Хүснэгтээс харахад ОНХС-гаас олгох санхүүжилтийг 2016 онд өмнөх оноос 32.7 хувиар бууруулан төлөвлөсөн бөгөөд 2015 онд ОНХС-гийн шилжүүлгийн орлогын төлөвлөгөө 82.2 хувийн биелэлттэй байсан бол 2016 онд санхүүжилтийг бүрэн олгосон байна.

2.5. Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтийг бүрэн олгосон байна.

2016 оны Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтийг УИХ-аас 7,500.8 сая төгрөгөөр баталсан МУ-ын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар 257.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж 7,758.3 сая төгрөгөөр баталсан бөгөөд гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн авсан байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

/сая төгрөгөөр/

Он	Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилт		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлтийн хувь
2015	7 236.9	7 107.6	98.2
2016	7 758.3	7 758.3	100.0

Хүснэгтээс харахад: 2016 онд Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтийг өмнөх оноос 6.7 хувиар нэмэгдүүлэн төлөвлөсөн бөгөөд 2015 онд улсын төсвийн орлого тасарснаас төлөвлөгөө 98.2 хувийн биелэлттэй байсан бол 2016 онд 100.0 хувийн биелэлттэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэмжээнд 2016 онд нийт 16,828.0 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөж батлуулснаас гүйцэтгэлээр 16,397.8 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

2.6. Тэнцлийн ашгийг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна.

2015 оны 12 дугаар сард аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор 2016 оны орон нутгийн төсвийн тэнцлийн алдагдлыг анх 226.2 сая төгрөгөөр нөхөж

санхүүжүүлэхээр төлөвлөн баталсан бөгөөд тайлант онд хийсэн 4 удаагийн төсвийн тодотголоор 432.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 658.6 сая төгрөгөөр баталсан байна.

Тэнцлийн ашгийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгааг өмнөх онтай харьцуулан хүснэгтээр харуулбал:

/сая төгрөгөөр/

Он	Тэнцлийн ашиг		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлтийн хувь
2015	1 312.9	1 084.2	82.6
2016	658.6	658.6	100.0

Хүснэгтээс харахад: 2016 онд тэнцлийн ашгийг өмнөх оноос 49.8 хувиар бууруулж төлөвлөсөн бөгөөд 2015 онд 587.6 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлж төлөвлөгөө 82.2 хувийн биелэлттэй байсан бол 2016 онд бүрэн төвлөрүүлсэн байна.

Орон нутгийн төсвийг үр ашигтай, үнэн зөв зарцуулсан эсэх

Бүлэг 3

Төсвийн хөрөнгийг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан боловч зарим зардлыг үр ашиггүй зарцуулсан байна.

3.1. ТЕЗ-ийн батлагдсан төсөв нийт дүнгээрээ хэмнэгдсэн хэдий ч төсвийн зарцуулалттай холбоотой зөрчил дутагдал байсаар байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэмжээнд 2016 онд нийт 16,828.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж батлуулснаас 14,704.0 сая төгрөг зарцуулж, төсөв 2,124.0 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Нийт хэмнэгдсэн зардлын 40.3 хувь нь бодит бус хэмнэлт байна. Тухайлбал: ТЕЗ-ийн 2016 оны төсвийн зарлагад сумдын СХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс олгох зээлийн дүнг оруулж баталсан боловч сангийн эх үүсвэр бүрдээгүйгээс зээл олголт төлөвлөсөн хэмжээгээр олгогдоогүй, мөн төсөвт байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөгөө тасарсантай холбоотой төсөв хэмнэгдсэн мэт харагдаж байна.

ТЕЗ-ийн 2016 оны нийт төсвийн гүйцэтгэлийн 47.3 хувь буюу 6,961.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт байгууллага, 52.7 хувь буюу 7,743.0 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын төсөв эзэлж байна.

Аудитаар ТЕЗ-ийн 2016 оны төсөв зарцуулалттай холбоотой дараах зөрчил дутагдал гарсан байна. Үүнд:

1. Зарим албан тушаалтны буруугаас ажлаас халагдсан хүмүүст шүүхийн шийдвэрээр нийт 51.1 сая төгрөгийг олгохоор тооцогдож, тайлант хугацаанд 30.1 сая төгрөгийг олгож төсвийг үргүй зарцуулсан байна.
2. Өмнөх оны төсвийн хэмнэлт буюу урамшуулал 157.3 сая төгрөгийг тайлант оны төсвийн гүйцэтгэлд тайлагнасан байна. Ингэснээр өмнөх оны төсвийн хэмнэлт, тайлант оны төсвийн гүйцэтгэл болж тайлагнагдаж байгаа ба урамшуулал зарцуулах журмын дагуу хөрөнгө бэлтгэсэн нь тайлант оны төсөвт зардлаас хөрөнгө бэлтгэснээр тайлагнагдсан байна.
3. Аймгийн Засаг даргын нөөц санд журмын дагуу нийт батлагдсан төсвийн 30 хувь буюу 39.0 сая төгрөгийг нөөцөд үлдээхээр байтал 21.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба 17.3 сая төгрөгийг илүү зарцуулсан байна.

4. ТЕЗ-ийн 2016 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн сахилга хариуцлагатай холбоотой 609.2 сая төгрөгийн зөрчил илэрч, аудитын явцад 1.7 сая төгрөгийн зөрчил дутагдлыг залруулж, 1.7 сая төгрөгийн төлбөрийн акт бичиж, 154.5 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 451.3 сая төгрөгийн зөрчил дутагдал арилгуулах зөвлөмж өгсөн байна.

Эдгээр нь Сангийн сайдын 2012 оны 239 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 5 дугаар зүйлийн 5.15-д “энэ журмын 2.1, 2.2-т зааснаас бусад зориулалтаар Засаг даргын нөөц хөрөнгөнөөс хөрөнгө оруулалтын зардал гаргах ...”, Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т” төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 14.2.3-т өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах” гэснийг зөрчсөн байна.

Нэмэлт санхүүжилтийн зарцуулалтын талаар

Нэмэлт санхүүжилтийн нэгтгэсэн тайлангаар мөнгөн хөрөнгө 2016 оны эхэнд 3.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 236.3 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, 236.3 сая төгрөгийг зарцуулж, өмнөх оны үлдэгдэл 3.0 сая төгрөгийг аймгийн орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт дансны орлого нь дараах эх үүсвэрээс бүрдсэн байна. Үүнд:

- НҮБ-аас 9.8 сая
- аймгийн БСГ-аас 23.9 сая,
- аймгийн Засаг даргын нөөц сангаас 10.5 сая
- архивын ажилчдын цалин 57.6 сая,
- ОНХС-аас төсөл хөтөлбөр, техник хяналтын зардалд 94.0 сая,
- харьяа дээд байгууллагуудаас 19.2 сая
- төсвийн урамшуулалд 0.4 сая,
- бусад хандив тусламжаар 20.9 сая төгрөг байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны орлогын 236.3 сая төгрөгийг хууль тогтоомжийн дагуу зарцуулж тайлагнасан байна.

3.2 2016 оноос төсөл сангийн орлого, зарлагыг төлөвлөж, төсвийн гүйцэтгэлийн тайланд тайлагнадаг болсонтой холбоотой ТЕЗ-ийн тайлангийн авлага нэмэгдсэн байна.

ТЕЗ-ийн хэмжээнд 2016 онд нийт 469.4 сая төгрөгийн өглөгтэй, 1,519.4 сая төгрөгийн авлагатай тайлагнагдсан бөгөөд өглөг өмнөх оноос 374.3 сая төгрөгөөр, 209.6 сая төгрөгөөр тус тус буурсан байна.


Нийт авлагын 19.2 хувь буюу 90.0 сая төгрөг нь орон нутгийн төсөвт байгууллагууд, 1,291.1 сая төгрөг нь төсөл сан, 127.0 сая төгрөг нь ОНӨААН, 11.3 сая нь ТЗШ-ийн байгууллагуудтай холбоотой байна.

Нийт өглөгийн 6.4 хувь буюу 96.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт байгууллагууд, 219.1 сая төгрөг нь төсөл сан, 117.4 сая төгрөг нь ОНӨААН, 36.0 сая нь ТЗШ-ийн байгууллагуудтай холбоотой байна.

а/ Орон нутгийн төсөвт байгууллагуудын нийт авлага, өглөгийг насжилтаар нь авч үзвэл:

Насжилт	Авлага		Өглөг	
	Дүн	Хувь	Дүн	Хувь
30 хүртэл хоног	1.8	2.0	68.0	70.2
31-60 хоног	4.5	5.0		
61-90 хоног	8.2	9.1	1.0	1.1
91-ээс дээш	75.5	83.9	27.8	28.7

Орон нутгийн төсөвт байгууллагуудын авлагын 2.0 хувь буюу 1.8 сая төгрөг нь 30 хүртэлх, 5.0 хувь буюу 4.5 сая төгрөг нь 31-60, 9.1 хувь нь буюу 8.2 сая төгрөг нь 61-90, 83.9 хувь буюу 75.7 сая төгрөг нь 91-ээс дээш хоногтой байна.



91-ээс дээш хоногтой 75.5 сая төгрөгийн авлага нь ОНХС-ийн хөрөнгөөр дутуу хийгдсэн ажилтай холбоотой бөгөөд тус авлагыг шүүхэд шилжүүлсэн байна.

Өглөгийн 70.2 хувь буюу 68.0 сая төгрөг нь 30 хүртэлх, 1.1 хувь нь буюу 1.0 сая төгрөг нь 61-90, 28.7 хувь буюу 27.8 сая төгрөг нь 91-ээс дээш хоногтой байна.

91-ээс дээш хоногтой 27.8 сая төгрөгийн өглөгийн 0.4 сая нь Баянтал сумын ЗДТГ-ын, 18.5 сая нь аймгийн ЗДТГ-ын, 0.7 сая нь ЗДНС-ийн, 8.2 сая төгрөг нь Цөм сүрэг үржлийн төвийн үйл ажиллагаатай холбоотой байна.

в/ Төсвийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын 2016 оны төсвийг өмнөх оноос 449.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 7,805.1 сая төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 7,743.0 төгрөг зарцуулж, 62.1 сая төгрөгийн төсвийн хэмнэлттэй ажилласан ба тайлант онд 11.3 сая төгрөгийн авлагатай, 33.7 сая төгрөгийн өглөгтэй тайлагнагдсан байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын авлага, өглөгийг насжилтаар нь авч үзвэл:

Насжилт	Авлага		Өглөг	
	Дүн	Хувь	Дүн	Хувь
30 хүртэл хоног			30.3	89.9
31-60 хоног	11.3	100.0	3.4	10.1
61-90 хоног				
91-ээс дээш				

ТЗШ-ийн байгууллагуудын авлага, өглөг нь 30-60 хоногтой байгаагаас үзэхэд өглөг, авлагыг 100.0 хувь барагдуулах боломжтой байна.

2016 онд тусгай шилжүүлгийн байгууллагуудын өглөг, авлагад аймгийн Засаг дарга, Санхүү, төрийн сангийн хэлтсээс онцгой анхаарч авлага, өглөгийг барагдуулах арга хэмжээ авч ажилласан боловч зарим байгууллагын нягтлан бодогч нарын хариуцлагагүй байдлаас шалтгаалан өглөг үүссэн байна. Тухайлбал: Боржигин чуулга 2016 оны төсвийн хэмнэлтэд 8.5 сая төгрөг төвлөрүүлсэн боловч 3.0 сая төгрөгийн өглөгтэй, Сүмбэр сумын 5 дугаар сургууль 2.4 сая төгрөг төвлөрүүлж, төсвийг 1.0 сая төгрөгөөр хэтрүүлэн 3.4 сая төгрөгийн өглөг үүсгэсэн, Насан туршийн боловсрол төвийн нягтлан бодогч өглөгийн тооцоог буруу гаргаж ирүүлснээс 2.6 сая төгрөгийн өглөг тус тус үүссэн байна.

2016 онд Шивээговь сумын Эрүүл мэндийн төвийн барилга шинээр ашиглалтанд орсон бөгөөд ашиглалтын зардлыг төлөвлөөгүйгээс 14.6 сая төгрөгийн өглөг нэмэгдсэн байна.

в/ 2016 оноос төсөл сангийн орлого, зарлагыг төлөвлөж, төсвийн гүйцэтгэлийн тайланд тайлагнадаг болсонтой холбоотой ТЭЗ-ийн тайлангийн өглөг, авлага нэмэгдсэн байна. Тухайлбал: Сумдын сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн 91-ээс дээш хоногтой авлага 1,291.8 сая төгрөг, ОНХС-ийн барьцаа хөрөнгийн өглөг 219.1 сая төгрөг байна. Цаашид сум хөгжүүлэх сангийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

3.3. Төсвийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих дотоод хяналт үр дүнгээ өгч байна.

Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, дотоод аудитыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий “Санхүүгийн хяналт, аудитын алба” аймгийн ЗДТГ-ын бүтцэд байгуулагдаж, 2016 онд нийт 11 байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг хамруулан шалгаж, 9.4 сая төгрөгийн зөрчил дутагдал илрүүлж, 3 акт бичсэн байна.

Тухайн тайлант хугацаанд хийгдсэн хяналт шалгалтаар нийтлэг дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Албан томилолтын хуудасны хоногийн тоог зассан, зардлыг илүү, дутуу олгосон, анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй. /Засгийн газрын 218-р тогтоолын 1-р хавсралтаар баталсан журмын 12-р заалт/
- Автомашины шатахууны зарцуулалтыг тооцохдоо нормоос илүү бодож олгосон, замын хуудас бичээгүй /Дэд бүтцийн сайдын 2004 оны 19-р тушаалаар батласан жишиг норм/
- Байгууллагын дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагааг зарим байгууллага огт хэрэгжүүлээгүй, зарим байгууллага нь дотоод хяналтыг хэрэгжүүлсэн боловч шаардлага хангахгүй байгаа, зөвхөн үндсэн үйл ажиллагаандаа хяналт тавьж, санхүүгийн үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлж чаддаггүй. /ЗГ-ын 311-р тогтоол/
- Байгууллагын удирдлагууд тушаал шийдвэр гаргахдаа хүчингүй болсон хууль тогтоомжийг хэрэглэсэн,
- Ажлаас халагдсан ажилтнуудтай ээлжийн амралтын тооцоо хийгээгүйгээс ээлжийн амралтын олговор дутуу олгодог, мөн ээлжийн амралтын мөнгийг илүү бодож өмнөх жилд бодсон амралтын мөнгийг давхардуулан тооцож олгосон. /Хөдөлмөрийн тухай хуулийн 55.1 дэх заалт/
- Өмнөх жилүүдийн мэргэжлийн хяналтын санхүүгийн хяналт шалгалтын актыг биелүүлээгүй,
- Ажилчдад цалингийн урьдчилгааг хууль тогтоомжийн дагуу тооцож олгоогүйгээс өглөг, авлага үүсдэг, ажилчдаас авах авлагаа дутуу суутгадаг, /НББТХуулийн 14.4.2 дахь заалтыг/

- ХЭДСангийн эргэн төлөгдөх нөхцөлтэй олгож буй зээлийн эргэн төлөлтөд хяналт тавьдаггүй, зээл хугацаандаа төлөгдөөгүй, иргэдэд ямар нэг хариуцлага тооцоогүй,
- Байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэл хангалтгүй, үндсэн хөрөнгөө коджуулаагүй, элэгдлийн хугацаа дууссан буюу ашиглах хугацаа нь дууссан, цаашид ашиглах боломжгүй болсон хөрөнгийг холбогдох газарт нь санал хүргүүлж шийдвэрлүүлдэггүй, /Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 зүйл/
- Нэг удаагийн тэтгэмж урамшууллыг хавтгайруулан олгодог, /Засгийн газрын 2004 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 112 дугаар тогтоол/
- Шагнал урамшууллыг олгохдоо ХХОАТатвар суутгадаггүй, /Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1,16.1.1,23.1, 26.1.1 дэх заалтууд/
- Ажилчдыг ажлаас үндэслэлгүй халдаг.

Дээрх зөрчлүүдийн улмаас Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаалуудын зөрчигдсөн бөгөөд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, зөрчил дутагдлыг арилгах талаар 8 зөвлөмж, 2 албан шаардлага өгч ажилласан нь үр дүнгээ өгсөн байна.

3.4. “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийг хангуулж, дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

2016 онд төсвийн болон орон нутгийн өмчит 74 байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж тайлан мэдээг улирал бүр Сангийн яамны Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт хүргүүлсэн байна. Мөн Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу харьяа 74 байгууллагаас түүвэрчлэн 34 байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхэд 264.1 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 154.1 сая төгрөгийн зөрчлийг шалгалтын явцад залруулсан байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд:

- Програмаас байгууллагууд татагддаггүй. /ШДТХуулийн 5.1.2 заалт/
- Цалингаас бусад 5 сая төгрөгнөөс дээш орлого, зарлагыг мэдээлээгүй /ШДТХуулийн 6.4.5 заалт
- Төсвийн хэтрэлт, хэмнэлтийн тайлбар бичээгүй. /ШДТХуулийн 6.3.3 заалт/
- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг хийдэггүй. /ШДТХуулийн 6.4.1 заалт/
- 5 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий бараа, худалдан авсан бараа ажил үйлчилгээний нэр, нийлүүлэгчдийн нэр хаягийг огт бөглөдөггүй. /ШДТХуулийн 6.4.4 заалт/ зэрэг зөрчлүүд илэрлээ.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.4-т “жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 4 дүрээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 8 дугаар сарын 15-ны дотор” гэснийг зөрчсөн байна.

Цаашид “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийг хангуулж, хяналтыг сайжруулах, байгууллагуудын шилэн дансны мэдээлэл хариуцсан ажилтнуудыг нэгдсэн нэг ойлголттой болгох талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. 2016 оны төсвийн төслийг боловсруулахдаа Сангийн яамнаас өгсөн чиглэлийн заримыг нь бүрэн хангаж ажиллаагүй байна.
2. Орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 580.7 сая төгрөг буюу 11.7 хувиар давж биелсэн байна.
3. Орон нутгийн холбогдох байгууллагуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй байгаагаас төсвийн орлого, зарлагыг бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөж, батлуулаагүй байна.
4. ТЕЗ-ийн батлагдсан төсөв нийт дүнгээрээ хэмнэгдсэн хэдий ч, төсвийн зарцуулалттай холбоотой зөрчил дутагдал байсаар байна.
5. ТЕЗ-ийн хэмжээнд төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 79.7 хувь буюу 856.6 сая төгрөгөөр тасарсан байна.
6. 2016 оноос төсөл сангийн орлого, зарлагыг төлөвлөж, төсвийн гүйцэтгэлийн тайланд тайлагнадаг болсонтой холбоотой ТЕЗ-ийн тайлангийн авлага нэмэгдсэн байна.
7. Төсвийн хөрөнгийг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан боловч зарим зардлыг үр ашиггүй зарцуулсан байна.
8. “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийг хангуулж, дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна.

- Орон нутгийн төсөвт бүрэн төвлөрөх боломжтой орлогын төлөвлөгөөг үндэслэлгүй бууруулж батлахгүй байх
- Өөрийн орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлэх
- Сумдын сум хөгжүүлэх сангийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах
- Төсвийн зарлагыг үндэслэлгүйгээр нэмэгдүүлж батлуулахгүй байх
- Төсвийн урамшууллын зардлыг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан бүртгэж, тайлагнах
- ЗДНС-гийн хөрөнгийг журмын дагуу зарцуулах
- “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийг хангуулж, хяналтыг сайжруулах